



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/15

Сант сум

Хурдан морины уралдаанч хүүхдийн амь
нас, эрүүл мэндийг хамгаалах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/36 тоот тушаалаар батлагдсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ийн хавсралт 3 дугаар зүйлийн 3.10.2, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/79 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор аймгийн хэмжээнд жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосугай.

2.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч, ахлах дэслэгч (Ж.Лхагважаргал)-д үүрэг болгосугай.

3.Холбогдох хууль, тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээлж, сурталчлан ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (С.Сайнхишиг)-д даалгасугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *С. Салтат*
Хянасан: *Ч. Вазир*
Хувь: *2.*
Огноо: *2023.02.09.*